



“ЖУУЛЧНЫ ХӨТӨЧ ТАЙЛБАРЛАГЧИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН СУДАЛГАА”

Асуулгын үр дүн (2024 оны 2р сар)

Монгол улс 2022 онд хилээ бүрэн нээснээр аялал жуулчлалын салбар сэргэх шатандаа орж, Аялал жуулчлалын тухай хууль болон дагалдах журмууд шинэчлэн батлагдаж, тус хуулийн дагуу Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо НЭЗХЭ шинээр байгуулагдсан байгаа энэ үед Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбооноос "Жуулчны хөтөч тайлбарлагчдын нөхцөл байдлын судалгаа"-г авч байна.

Судалгааны зорилго, цар хүрээ:

- Ковид-19 цар тахлаас хойших жуулчны хөтөч тайлбарлагчийн тоог зах зээл тус бүрээр тоймлох, сургалтад хамрагдсан байдал болон сургалтын хэрэгцээг илрүүлэх
- Хөтөч тайлбарлагчийн үйл ажиллагаанаас олох орлогыг тоймлон гаргаж, энэ хэмжээ нь АЖМХ-ны гишүүнчлэлийн татвартай уялдаж буй эсэхийг тодруулах
- Хөтөч тайлбарлагчид тулгардаг нийгмийн асуудлууд, ажлын байранд үүсдэг хүндрэл бэрхшээлийг илрүүлэх

Судалгааны хамрах хүрээ:

2024 оны 2р сарын 20-ны өдөр Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоо нь БОАЖЯ-ны ивээл дор Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны дэмжлэгтэйгээр зохион байгуулсан Жуулчны хөтөч тайлбарлагчийн III чуулганы үеэр тус санал асуулгыг нийтэд зарлан авсан. Мөн дараа нь санал асуулгын холбоосыг Холбооны пэйж болон бусад фэйсбүүк сувгуудаар 7 хоногийн турш хүргэж, нийт 160 жуулчны хөтөч тайлбарлагч хамрагдав.

Судалгааны арга зүй:


Судалгааг сонголтот болон нээлттэй 23 асуулт бүхий асуумжаар авлаа. Хувь хүний нэр хүнд, нууцад нөлөөлөхүйц (жилийн орлого, бэлгийн хүчирхийлэлд өртсөн эсэх гм) асуулт орсон тул нэр, мэйл хаяг цуглуулах тохиргоогүйгээр авсан болно.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:


- Судалгаанд оролцогсдын тал шахам буюу 48,1 хувийг 31-40 насныхан, үүн дээр 41-45 насныхан 16,2 % эзэлж байгаа нь нийт хөтөч нарын 3 хүн тутмын 2 нь 31-45 насныхан байгааг харуулж байна.

Таны нас
160 responses



- Хүйсээр нь авч үзвэл 68.8 % нь эмэгтэй, 31.3 % нь эрэгтэй байна.

Хүйс
160 responses




- Хэлний хувьд ихэвчлэн хөтөч хийдэг зөвхөн НЭГ хэлийг сонгох байдлаар асуусан бөгөөд 160 хүнээс солонгос хэлээр 82 (51.2%), англи хэлээр 43 (26.9%), герман,

франц хэлээр тус бүр 10 (6.3%), япон хэлээр 6 (3.7%), хятад, испани хэлээр тус бүр 2 (1.2%), вьетнам, монгол, итали хэлээр тус бүр 1 хүн хөтөч хийдэг гэж хариулжээ.¹

Та аль хэлээр хөтөч хийдэг вэ? (Ихэвчлэн хөтөч хийдэг нэг хэлээ сонгоно уу)

160 responses




- **Хөтчөөр ажилласан туршлагаар** нь авч үзвэл 35 орчим хувь нь 1-3 хүртэл жилийн туршлагатай, эсвэл хараахан ажиллаж үзээгүй, 35 орчим % нь 4-9 жил ажилласан, 10-с дээш жил ажилласан хөтөч 30 орчим хувьтай байна.

¹ 2021 онд Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбооноос 192 хөтөч тайлбарлагчдын дунд хийсэн “Ковид-19 цар тахлын үеийн аялын хөтөч тайлбарлагчдын нөхцөл байдал” судалгаанд англи хэлтэн 52.4, франц хэлтэн 15.2, солонгос хэлтэн 14.1, герман хэлтэн 8.4 хувийг тус тус эзэлж байв.

Хэдэн жил жуулчны хөтөч тайлбарлагчаар ажиллаж байна вэ?

160 responses




Тэдний 73 орчим хувь нь (115 хүн) Улаанбаатар хот болон орон нутагт, 15.2 % (24 хүн) нь Улаанбаатар хот, орон нутаг, гадаадад 5.1 % (8 хүн) зөвхөн орон нутагт хөтчөөр ажиллаж байна.

- **Аяллын төрлийн тухайд** асуулгад оролцсон 160 хүний давхардсан тоогоор 127 нь авто машинтай, цөөн хүнтэй тойрон аялалд, 111 хүн нь групп аялал (package)-д түлхүү ажилладаг гэсэн бол тусгай сонирхлын аяллуудаас морь/тэмээ энгийн хөсгөөр аялах аялалд 72, уулын болон явган аялалд 67 хүн, шашин соёлын аялалд 41 хүн хөтчөөр ажилладаг гэж хариулжээ.
- **Жилд ажиллах хугацаа болон нөхцөлийн хувьд**, судалгаанд оролцсон 160 хүний тал шахам буюу 75 хүн (46.9 %) нь жилд 61-с дээш хоног, 42 хүн (26.3 %) нь 31-60 хоног, 34 хүн (21.3 %) нь 1-30 хоног хөтчөөр ажилладаг гэсэн бол 9 хүн (5.7 %) нь хөтчөөр хараахан ажиллаж үзээгүй байна.

Жуулчны хөтөч тайлбарлагчаар жилд ойролцоогоор хэд хоног ажилладаг вэ?

160 responses



Ийнхүү ажиллахдаа 2023 оны байдлаар, нийт судалгаанд хамрагдагсдын 71 нь (44.4%) 1 ажил олгогчтой, 38 (23.7%) нь хоёр, 22 нь (13.8%) 3 ажил олгогчтой ажилласан байна. Бусад нь 4 болон түүнээс дээш ажил олгогчтой, эсвэл өөрийн үүсгэсэн компанидаа хөтчөөр ажиллаж байна.


Гэвч тэдний 49 нь буюу 30.6 % нь НДШ огт төлдөггүй, 42 нь буюу 26.3% нь сайн дурын даатгалд хамрагддаг, 21 нь буюу 13.1% нь үндсэн ажлын байраараа дамжуулан НДШ төлдөг бол ердөө 9 хүн буюу 5.6 % нь ТО-р дамжуулан жилийн турш, мөн 10% нь зөвхөн хөтчөөр ажиллаж байхад нь ТО-с НДШ төлдөг гэж хариулсан байна. ²

² Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбооноос 2021 онд хийсэн “Ковид-19 цар тахлын үеийн аяллын хөтөч тайлбарлагчдын нөхцөл байдал” судалгаагаар (192 оролцогч) хөтөч нарын 43.2 % нь нэг ажил олгогчтой ажилладаг гэсэн тоо бараг өөрчлөгдөөгүй аж. Мөн тэдний 19.9 % нь НДШ огт төлдөггүй, 22 % нь сайн дурын даатгалд хамрагддаг гэж хариулж байжээ. Түүнтэй харьцуулахад одоо 2024 оны байдлаар НДШ төлдөггүй хөтөч нарын тоо 30.6 болж 10 орчим хувиар өссөн харагдаж байна.

Гэвч энэ дүнтэй эсрэгцэн НДШ төлөхийг хүсдэг нь дийлэнх олонх (66.3 %) байгааг дараах графикаас харж болно.

НДШ төлөхийг (одоо төлдөг, төлдөггүй эсэхээс үл хамааран) хүсдэг үү?


160 responses



- Орлого:** Судалгаанд хамрагдсан 160 хүний 15 нь (9.4%) жилдээ 25-с дээш сая төгрөг, 27 (16.9%) нь 15-25 хүртэл сая төгрөг, 28 нь (17.5%) нь 9-15 хүртэл сая төгрөг, 30 хүн (18.8%) нь 6-9 хүртэл сая төгрөг, 50 хүн 6 хүртэл сая төгрөгийн орлогыг хөтөч тайлбарлагчийн үйл ажиллагаанаас олдог байна. 10 хүн нь одоогоор хөтчөөр ажиллаж үзээгүй гэжээ.

Жуулчны хөтөч тайлбарлагчаар ажиллаад жилд ойролцоогоор хэдэн төгрөгний орлого олдог вэ? (цалин, урамшуулал, гарын мөнгө нийтэд нь)

160 responses




Үүнээс үзвэл, ойролцоогоор 4 хөтөч тайлбарлагчийн нэг нь жилд 15-с дээш сая төгрөг буюу дундаж цалингийн³ хэмжээтэй дөхүү, эсвэл илүү орлогыг хөтөч тайлбарлагчийн үйл ажиллагаанаас олж байна. Гэвч энэ нь зөвхөн цалин бус, нэмэлт урамшуулал, гарын мөнгө зэргийг хамруулан асуусан тул зах зээл, аяллын онцлог зэргээс шалтгаалан ялгаатай байхыг анхаарна уу.

- Хөтчийн үйл ажиллагаанаас олох орлого нь 52 (38.7%) оролцогчийн хувьд жилийн нийт орлогын 60-аас дээш хувийг эзэлдэг болохыг доорх графикаас харж болно.

Жуулчны хөтөч тайлбарлагчаар ажиллаж олох орлого нь таны жилийн нийт орлогын хэдэн хувийг эзэлдэг вэ?

160 responses




2. Сургалт

- Судалгаанд хамрагдагсдын 83.8 % нь 14 болон түүнээс дээш хоног (50 цаг) үргэлжлэх хөтөч тайлбарлагчийн сургалтад хамрагдсан бөгөөд, сургалтын байгууллагаар нь авч үзвэл Мэргэжлийн Хөтөч Тайлбарлагчдын Холбоо, Guide төвөөс зохион явуулдаг төлбөртэй сургалтуудад хамгийн олноор хамрагджээ.

³ Үндэсний статистикийн хороо 2023 оны 2р улиралд дундаж цалинг 1,9 сая гэж тооцсон.
https://downloads.1212.mn/iDqf_WUqUd8_K_32iKf-mesEqjNY-JJy9RU5j-_r.pdf

Жуулчны хөтөч тайлбарлагчийн ур чадвар, ерөнхий мэдлэгийн 14 хоногоос дээш (50 цагаас дээш) үргэлжлэх сургалтад хамрагдсан бол дара...гдаагүй бол "бусад" хэсэгт тодорхой бичнэ үү.


149 responses



- **Цаашид ямар сургалт авахыг хүсэж байгааг асуухад түүх, археологи, шашин соёл, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх, хөтчийн ур чадварын болон газарзүй, палеонтологийн сургалтууд хамгийн эрэлт хэрэгцээтэй байна. Түүнчлэн салбарын хууль эрх зүйн орчны талаарх сургалт багагүй эрэлттэй байгаа нь анхаарал татлаа.**

Аль сургалт танд нэн чухал хэрэгтэй байна вэ? Чухал гэж бодсон 5 (тав) хүртэл сонголтыг дугуйлна уу. Нэмэлтээр бичих бол "Бусад" хэсэгт дэлгэрэнгүй бичнэ үү.

160 responses




3. АЖЛЫН БАЙРАН ДАХ АЮУЛ ЭРСДЭЛ

- Судалгаанд оролцогчдын 54 нь (33.8%) ажил үүргээ гүйцэтгэж явахдаа гэнэтийн осолд өртөж, бие махбодоороо хохирч байсан ба 71 хүний хувьд хамгийн түгээмэл осол нь мал амьтнаас унах, ойчих (44 хүн буюу 62%) мал амьтанд тийрүүлэх, өшиглүүлэх, хазуулах, хатгуулах (15 хүн буюу 21.1%), үер ус, цас бороо, шуурганд дайруулах (17 хүн буюу 23.9%) болон машин, мотоциклын ослууд (15 хүн буюу 21.1%) байна. Түүнчлэн бэлгийн хүчирхийлэлд 10, хулгай дээрэмд өртсөн 7 тохиолдол тэмдэглэжээ.

Энд судалгаанд оролцогчдын 54 нь гэнэтийн осолд өртөж байсан гэсэн боловч ослын задаргаагаар асуухад 71 хүн бөглөсөн байгаа тул зарим хариулт нь алдаатай байж болохыг анхаарна уу.


Осолд өртөж, бие махбодоороо гэмтэж байсан бол доорх жагсаалтаас хамаарах бүгдийг сонгоно уу. Осолд өртөөгүй бол энэ асуултыг хариулалгүй үлдээнэ үү.

71 responses



• **АЖИЛ ОЛГОГЧИЙН зүгээс эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдлүүд (судалгаанд хамрагдсан 160)**

Таныг ЖХТ-ийн ажил үүргээ гүйцэтгэж байхад АЖИЛ ОЛГОГЧИЙН зүгээс эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гаргадаг уу? Давтамжийг тэмдэглэнэ үү.



Хүснэгт №1. Ажил олгогчийн зүгээс эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдэл (давтамжаар)

№	Асуулт/Давтамж	Их	Заримдаа	Хааяа	1-2 удаа	Тохиолдоогүй
1	Цалин өгөхгүй байх	5	11	3	19	122
2	Шалиг үг ярих, зохисгүй харилцаанд уруу татах	3	17	7	16	117
3	Ажлын нөхцөл гэрээнд зааснаас (ярьж тохирсноос) муу байх	4	20	9	34	93
4	Ажлаа хийх үед сүрдүүлэх, хэл амаар доромжлох	4	13	3	12	128
5	Зодох, дээрэлхэх	2	8	1	2	147
6	Хүчиндэх	2	9	0	0	149
7	Цалин, урамшууллыг гэрээнд зааснаас дутуу юм уу хоцроож өгөх	3	11	8	27	111
8	Хүчиндэхийг завдах	2	9	1	1	147
9	Шалтгаангүйгээр гэмт хэрэгт гүжирдэх	2	9	1	7	141
10	Амралтгүй ажиллахыг шаардах	5	12	3	23	117

Хүснэгт №1-ээс харахад ажил олгогчийн зүгээс *хөтөч тайлбарлагчийн цалинг ярьж тохирсон, гэрээнд зааснаараа өгөхгүй байх, ажлын нөхцөл гэрээнд зааснаас муу байх, амралтгүй ажиллахыг шаардах* зэрэг асуудал хамгийн түгээмэл байна. Түүнчлэн *бэлгийн хүчирхийлэл, зодох дээрэлхэх* тохиолдол гарсан байгаад анхаарал хандуулан энэ чиглэлээр нарийвчлан судалгаа авах хэрэгтэй гэж үзэж байна.

Дээрх асуултуудад багтаагүй өөр асуудал байгаа эсэхийг илрүүлэх зорилгоор нээлттэй асуултад

“Ажил угчууд тсалиндеerei новширдог”

“Ажил олгогч хөтөлбөрөө буруу боловсруулсан, хөтөлбөр буруу орчуулга хийдэг.”

“Хэзээ ч гэрээгээрээ яваагүй”

“Мэргэжлийн бус байдлаар хандан жуулчидтай нийлж гүтгэх сэтгэл зүйн болон хөдөлмөрийн мөлжлөг буюу цалин хассан...”

“Компани жуулчнаа авахын тулд хэтрүүлэгтэйгээр аялалын бүтээгдэхүүнээ ярьснаас болж бодит байдал дээр зөрчилдөх асуудалтай их тулгардаг. Энэ үед сэтгэл санаа л их гэмтдэг. Сэтгэл санаагаар их ядардаг. Нэг талаас жуулчид маань өрөвдөлтэй ч юм шиг... Хоол хийж явдаг аялал их аюултай санагддаг. Гаазан плитка ашиглана заримдаа шаардлага хангахгүй плитка явж байдаг. Эрүүл мэндийн %д ходоодны өвчинд өртөмхий болох юм шиг санагддаг. Гэхдээ энэ нь хэн нэгнээс хамаарах биш өөрөө арчаатай дэгтэй байвал гайгүй л бх л даа.”

“Ажил олгогчийн зүгээс техник хэрэгслийн бүрэн бүтэн байдал хангаагүйн улмаас нэг аялалд Знтаа машин сольж, цаг алдсан учраас маршрутад орсон газруудаа үзэж амжихгүйд хүрсэн. Жуулчдын зүгээс гомдол гаргахад компани хөтчийн буруутай оройтуулсан гэх маягаар хандсан учраас аргагүйдээж аяллаа дундаас нь цуцалсан тохиолдол бий.”

“Аяга таваг хагалсан, эд хэрэгсэл эвдэрсэн буюу муудсан гэх үндэслэлээр цалингаас хасуулж байсан буюу хэд нугарсан үнэ төлж байсан.”


“Хөтөлбөр зөрөх зүйл ганц хоёр гарсан...”

“Ажил олгогчоос хүйсээр ялгаварлах, цалин ялгавартай өгөх, ажилд цөан гаргах тохиолдол байна...”

гэж хариулснаас үзвэл хөтөч тайлбарлагч нарын ажил олгогчтой байгуулсан гэрээний нөхцөл зөрчигдөх, ХАБЭА хангаагүй нөхцөлд ажиллах, ажил олгогчтой бүрэн ойлголцохгүй байх асуудал үүсдэг байна.

- **ХАМТРАН АЖИЛЛАГЧ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН** зүгээс эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдлүүд (судалгаанд хамрагдсан 160)

Таныг ЖХТ-ийн ажил үүргээ гүйцэтгэж байхад ХАМТРАН АЖИЛЛАГЧ, ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧИЙН (жолооч, тогооч, нутгийн хөтөч, бааз/буудал/зочин хүлээн авагч айл, ресторан, үзвэр үйлчилгээний газар, аяллын туслах, өөр аяллын ЖХТ гм) зүгээс эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гаргадаг уу? Давтамжийг тэмдэглэнэ үү.



Хүснэгт №2. Хамтран ажиллагч, ханган нийлүүлэгчийн зүгээс эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдэл (давтамжаар)

№	Асуулт/Давтамж	Их	Заримдаа	Хааяа	1-2 удаа	Тохиолдоогүй
1	Шалиг үг ярих, зохисгүй харилцаанд уруу татах	12	29	18	32	69
2	Ажлаа хийх үед сүрдүүлэх, хэл амаар доромжлох	4	18	17	27	94
3	Зодох, дээрэлхэх	1	11	8	10	130
4	Хүчиндэх	1	11	3	5	140
5	Хүчиндэхийг завдах	2	11	5	22	120
6	Шалтгаангүйгээр гэмт хэрэгт гүжирдэх	1	11	4	19	125
7	Архи, мансууруулах бодис санал болгох, шахах	9	15	10	44	82
8	Ажил олгогчтой гэрээлсэн нөхцөлөөс өөр нөхцөл тулгах (баазад ор гаргаж өгөхгүй бх, хоол өгөхгүй бх гм.)	7	20	13	37	81

Хүснэгт №2-с харахад хамтран ажиллагч, ханган нийлүүлэгчийн зүгээс *шалиг үг ярих, зохисгүй харилцаанд уруу татах, архи, мансууруулах бодис санал болгох, сүрдүүлж, хэл*



амаар доромжлох, ажил олгогчтой гэрээлснээс өөр нөхцөл тулгах зэрэг асуудал хамгийн түгээмэл байна. Түүнчлэн хүчиндэх, хүчиндэхийг завдах тохиолдол байгааг анхаарууштай.

Мөн асуулгын энэ хэсэг нь хөтөч тайлбарлагчтай хамтран ажилладаг, үйлчилгээг ханган нийлүүлдэг бүх талуудыг нэгтгэсэн тул аль оролцогч талд ямар асуудал илүүтэй үүсдэгийг нарийн тодруулах судалгаа тусад нь хийх хэрэгцээ байна гэж үзэж байна.

Дээрх асуултуудад багтаагүй өөр ямар асуудал байгааг илрүүлэх зорилгоор нээлттэй асуухад баазад эрэгтэй, эмэгтэйгээр ялгаж оруулахгүй байх нь дарамттай байгаа, зарим жолооч архи уудаг, хөтөч газар мэдэхгүйг далимдуулан өөр замаар явдаг, жуулчнаас гарын мөнгө нэхэхийг шаарддаг, архи тамхи авч өгүүлэх гэдэг гэх мэт агуулга бүхий дараах хариултуудыг өгсөн байна.

“Purgonii болон иhenhi орон nutgiin Jolooch nariig soyoltoi baigaasai gj boddog...nutgaasaa oor gazar zam medku , emegtei juulchin haraad ynz ynziin reaction gargaad bdag..tegsnee hool bairaa Dandaa golno, zamdaa tamhi piwo awhuulah gj hereldene...baigaliin haragdatsgui towch binzen hemneh zamaar ywkaad guriigeed hereldeed bdag...mashin ewderchlee ged zasah Hun duustsan gd untaad ogdog...guiduudiig juulchnaas gariin mongo awch og gj heleeteh geh meteer shaarddag geh met mashintai bolgoniig awch ywaad Bhar ersdel ondor bna”

“Жолооч нар болон, баазын ажилчдын ёс бус хэргүүд байдаг”

“... Бас зарим жолооч нар хэл амаар доромжлох тохиолдол их гардаг...”

“...Мөн жуулчны баазуудад эрэгтэйчүүдийн хамт оруулснаас айж дарамттай нойргүй хонох асуудал бдаг”

“Бааз тухгүй нэмж мөнгө шаардсан”

“Одоог болтол эрэгтэйчүүдтэй нэг гэрт хуваарилдаг хэвээрээ байгаа. Аяалал ихтэй солих боломжгүй гэдэг”

“нэг амралтын газар байрласан ямар ч хамааралгүй аялал жуулчлалын байгууллагын захирал хүн хэл амаар доромжилж байсан”

“...Бас зарим жолооч нар намайг зам мэдэхгүйг далимдуулж хөтөлбөрт заагдсан газрыг алагсуулахыг оролдсон...”

“...хамтрагч хөтөч нар хэт их архидах явдал их...”

- **ЖУУЛЧИН** буюу үйлчлүүлэгчийн зүгээс эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдэл гаргадаг эсэх талаар асуухад ажлын бус цагаар ажиллахыг шаардах, ажлаа хийх явцад хэл амаар доромжлох, шалиг үг ярьж зохисгүй харилцаанд уруу татах үйлдэл гаргах гэсэн сонголт хамгийн түгээмэл байна.

Таныг ЖХТ-ийн ажил үүргээ гүйцэтгэж байхад ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН (жуулчин) зүгээс эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл гаргадаг уу? Давтамжийг тэмдэглэнэ үү.



Хүснэгт №3. Жуулчны зүгээс эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн үйлдэл (давтамжаар)

№	Асуулт/Давтамж	Их	Заримдаа	Хааяа	1-2 удаа	Тохиолдоогүй
1	Шалиг үг ярих, зохисгүй харилцаанд уруу татах	4	14	5	18	119
2	Хэл амаар доромжлох	4	13	7	31	105
3	Зодох, дээрэлхэх	1	12	2	8	137
4	Хүчиндэх	1	11	1	5	142
5	Хүчиндэхийг завдах	1	11	1	8	139

6	Шалтгаангүйгээр гэмт хэрэгт гүжирдэх	1	13	2	11	133
7	Архи, мансууруулах бодис санал болгох, шахах	5	11	5	25	114
8	Ажлын бус цагаар ажиллахыг шаардах	7	12	8	28	105

Өөр асуудал байгаа эсэхийг нээлттэйгээр асуухад

“Байгалийн давтагдашгүй хүчин зүйлсээс болж маршрут өөрчлөгдөхөд жуулчид хариуцлагыг хөтчөөс нэхдэг.”

“Жуулчин хулгайд утсаа алдснаас болж маш эвгүй байдалд орж байсан.”

гэсэн хариултууд өгсөн байна.

Үүнээс, хөтөч тайлбарлагчид өөрийнхөө эрх, үүргийг нарийн ялгаж мэддэггүй, хуулийн хүрээнд өөрийгөө хамгаалах мэдлэг мэдээлэл хэрэгтэй гэж анзаарагдлаа.

• САНАЛ ХҮСЭЛТ

Асуулгын төгсгөл хэсэгт “Монголд жуулчны хөтөч тайлбарлагчаар ажиллахдаа бүрэн сэтгэл хангалуун байдаг” эсэх талаар асуухад 160 оролцогчийн 94 нь (58.8%) “тийм”, 57 (35.6%) нь “үгүй”, 9 (5.6%) нь “хараахан ажиллаж эхлээгүй” хариу өгчээ.

Эцэст нь *ЖХТ-ийн ажиллах нөхцөлийг сайжруулахын тулд хэн, юу хийх хэрэгтэй байгаа талаар* нээлттэй асуухад “нийтийн бие засах газрыг сайжруулах” 18 хүн, АЖМХ-ны гишүүнчлэл өндөр байгаа талаар 10 хүн, төр өөрийнхөө үүргийг өөрөө хэрэгжүүлэх хэрэгтэй талаар 8 хүн, салбарын бусад оролцогч, ялангуяа бааз болон жолоочтой үүсдэг асуудлын талаар 22 хүн, зам харилцаа муу байгаа талаар 12 хүн, зам дагуух хоолны чанар хангалтгүй байгаа талаар 6 хүн, салбарын стандарт байхгүй, эсвэл тодорхой биш байгаа талаар 8 хүн, хөтчийн мэдээллийн сантай болох тухайд 5 хүн, хөтөч нарын мэдлэг муу байгаа талаар 6 хүн, хөтчин нийгмийн асуудал, ХАБЭА хангагдахгүй байгаа талаар 8 хүн гэх мэтээр санал илэрхийлсэн байна.



ЖХТ нар ажлаа хийхэд, зам дагуух нийтийн 00 болон ариун цэвэр байдал, зам харилцаа, машины зогсоол чанарын шаардлагагүй хангахгүй гэжээ. Түүнчлэн, жуулчны баазууд стандарт байхгүй, эсвэл түүнийгээ баримталдаггүй байгаа нь ажил хийхэд сөргөөр нөлөөлдөг.

Мөн жолооч нар архи уух, хөтчийг дээрэлхэх зэргээр хамтран ажиллахдаа муу тул тэднийг сургах шаардлага байгаа талаар дурдсан байна. Салбарын бусад оролцогчийн зүгээс үнээ жигд байлгах, гадаад монгол гэж ялгахгүй харилцахад анхаарах тухай дурдсан.

Түүнчлэн, хөтөч нар зах зээлээрээ талцах үзэгдэл байгаа, нэгдсэн мэдээллийн сан байхгүйгээс хүн бүр мэдээллийг дур зоргоороо хүргэж байгаа зэрэгт санаа зовж буйгаа мөн илэрхийлсэн байна. Хөтөч нар тодорхой байгууллагад татвар төлснөөрөө эрхээ хамгаалуулах, цалингийн хэмжээ тогтвортой байлгах талаар санал мөн гарсан.

Нөгөөтээгүүр, гишүүнлэлийн хураамжийг хэрхэн зарцуулах нь ойлгомжгүй байгаад бухимдсан, хураамжийг огт төлөхгүй гэсэн саналууд мөн олон гарсан байна.

“ЖХТ-ийн ажиллах нөхцөлийг сайжруулахын тулд хэн, юу хийх хэрэгтэй вэ?” нээлттэй асуултаар авсан доорх саналуудыг [Хавсралт 1](#)-с дэлгэрүүлэн үзнэ үү.

ДҮГНЭЛТ

- Ковид-19 цар тахлаас хойш салбар дахин сэргэж, Аялал жуулчлалын хууль шинэчлэн батлагдаж, түүний дагуу АЖМХолбоо НЭЗХЭ үүсгэн байгуулагдаж, Жуулчны хөтөч тайлбарлагчдыг үнэмлэхжүүлэх, зэрэг олгохтой холбоотой журам хэрэгжиж эхлэх болсон цаг үед жуулчны хөтөч тайлбарлагчдын нөхцөл байдлыг илрүүлэхээр асуулга судалгааг хийж, нийт 160 хөтөч тайлбарлагч болон хөтөч тайлбарлагчаар ажиллах зорилготой иргэд хамрагдлаа.
- Нийт судалгаанд хамрагдагсдын тал орчим хувь нь солонгос хэлтэн байгаа нь тус зах зээл салбарт эрчтэй хөгжиж буйн нотолгоо. Нийт судалгаанд оролцогсдын тус мэргэжлээр ажилласан туршлагын хувьд ажиллаж үзээгүй болон 3 хүртэл жил ажилласан нь 35 хувийг эзэлж байна. Судалгаанд оролцогсдын дийлэнх олонх буюу 80 гаруй хувь нь чиглэлийн сургалтуудад хамрагдсан боловч түүх археологи, шашин соёл, хөтчийн ур чадварын болон анхны тусламж үзүүлэх гэх мэт сургалт эрэлттэй байсаар байна.
- Судалгаанд оролцогсдын 43 хувь нь нэг ажил олгогчтой харилцдаг боловч ихэнх нь НДШ төлдөггүй, жилд ажиллах хугацаа, орлогын хэмжээ харилцан адилгүй байна. Хөтчийн үйл ажиллагаанаас жилд 15 сая-с дээш төгрөгний орлоготой ажилладаг хөтөч ердөө ¼ орчим, бусад нь түүнээс доош хэмжээний орлогыг олж байна.
- Ажлаа хийх явцад жолооч, бааз зэрэг хамтран ажиллагч, ханган нийлүүлэгч байгууллагатай ажиллахад бэрхшээл үүсдэг, дарамт мэдэрдэг, түүнчлэн морь/тэмээнээс унах зэргээр эрсдэлтэй нөхцөлд ажилладаг ч компанийн зүгээс ХАБЭА анхаардаггүй, гэрээгээ зөрчдөг байх нь түгээмэл гэж дурджээ.
- Яам болон төрийн байгууллагууд нийтийн 00, зам харилцааг сайжруулахад анхаарах, бааз болон бусад ханган нийлүүлэгч байгууллагад стандарт хэвшүүлэх, хөтөч нарын ХАБЭА-г хамгаалах арга хэмжээ авах, стандарт мөрдүүлэх, хөтөч/жолооч аль алинд нь сургалт явуулах гэсэн хүсэлтүүд нийтлэг байна. Түүнчлэн АЖМХ-нд гишүүнээр элсэх 600,000 төгрөгийн хураамжийг юунд зарцуулах нь тодорхойгүй, эсвэл хэмжээ нь их байна зэрэг шалтгаанаар хүчтэй эсэргүүцсэн саналууд олон гарлаа.

Hutuch joloch nariig busad uilchlvvlegch nartai adilhan handahiig juulchni baaz nar anhaarwal zvgeer bn
нийтийн бие засах газар олноор байгуулах
Jildee 2,3 ydaa l ayalliin hutuch-tailbarlagchaar yawdag болсон тул 600.000 tatwar het unetei bn. Ajillaj bгаа kompanidaa 18 jil tatwaraa huuliin daguu tulj irsen
Salbaraa tsegtsleh, standartjuulah.
Хууль хэрэгжүүлэгч байгууллагууд албан ёсны мэргэжлийн чиг хандлага болон дүрэм журамыг баримтлаж шүүлтүүр шаардлагыг тавьж эрх тэгш ажиллах
Нийгмийн хамгаалал, аюулгүй байдал, даатгалын орчин дутмаг байна.
Ene heden hun holboo ntr geed ygd bidnariig bazahgaad baigaag nnoilgohgui bn bas 600k tatvar tulnu gh shig tgne urdni buh sertpikat huchingui holbooni l unemeleh zaav l avna gh shig bas udaan ajil hiitsen hguiduuda ingej daramtlaj bolohgui !! Mergejiliin hutuch tailbariin holboo! Bas Yam!
Зөвхөн аялал жуулчлалын салбарын хүмүүс биш хот орон нутаг албан байгууллагууд ариун цэвэр дээрээ анхаарах, гадаах орчин тойрноо хариуцаж цэвэр байлгах тал дээр ажилмаар байна. Пу гэж таьлбарлахаа ч мэдэргүй нөхцөл байдлууд зөндөө үүсдэг өө манай улс угаасаа ийм заваан гэх үү.... Морь тэмээ унуулж байгаа хүмүүс маань мөнгө чухал ч гэсэн морь малаа амрааж сургаж баймаар байна жуулчины хөлийг морь хазчихаад байхад хэв нэг инээгээд зүгээр дээ гээд өнгөрсөн тохиолдол гарч байсан. Үнэ хөлс дээрээ тогтсон өртөгтэй байлгамаар байна. Гадаад жуулчид харахаараа хүссэнээрээ нэмдэг үйл явц цааш цаашдаа жуулчин ирэхээ болих үндэс болно. Амралтын газруудад стандарт тавих түүндээ шалгалт тавих.
эрхзүйн орчныг сайжруулах,
Хураамж, гишүүнчлэлийн мөнгөн дүн маш өндөр байгаад гайхаж байна. Улиралын чанартай ачаалалтай ажилд ямар өндөр хураамж авах гээд байгааг ойлгохгүй, дэмжихгүй байна.
Төрийн байгууллагууд
Мэргэжлийн байгууллагад зохих төлбөрийг нь төлөн бүртгүүлээд, эрх зүйн хамгаалалт болон тасралтгүй сургалтад хамрагдах



Хээрийн хоол унд хийх нь хөтөчийн ажил биш гэж бодож бн. Жолооч нар хүний амь нас хариуцаж байж архиддаг. Хэлэхээр хэл амаар доромжилдог. Шалиг үг яриатай
Сургалтанд байнга хамруулах жолооч guide хамт
00-н асуудал шийдэх хэрэгтэй
баазын стадарт муу
Гадны нөлөөнөөс сэтгэл хангалуун бус байдаг. Жишээ нь аялах замд таарах ариун цэврийн өрөө, цайны газрын хоол гэх мэт..
асуудал бол маш их бна 1. замын асуудал 2. түгжрэлийн асуудал 3. нойлын асуудал 3. базын асуудал
00 ийн асуудал маш хэцүү
Хөгчийн талаарх ойлголтыг мэргэжлийн зүгээс олон хүнд хүлээн зөвшөөрүүлэх
00 asiudal,zam hariltsaa
Орчин тийм таатай бишээ
Menegment
Сургалтууд зохион байгуулах
Ажил олгогч
Эрүүл цэгцтэй болгох мэдээ мэдээллээ нээлттэй байлгах
хөдөө орон нутагт 00ыг шийдвэрлэх
нийтийн жорлон сайжруулах хэрэгтэй
berteh hemjeenii osol garj bgaagyι
Жилийн хураамж өндөр байна
Sainnmedehgui



Ер нь тогтолцоо муу, ххрилцаа уялдаагүй, аялахд хүндрэлтэй
Хөдөлмөр нийгэм хамгааллын яам, Боловсролын яам, Эрзүл мэндийн яамдуутай хамтрах, Хөгчийн холбоо маань илүү гишүүнээ нэмэх
Жуулчны баазуудад стандарт тавьж стандартад нийцэхгүй тохиолдолд арга хэмжээ авах шаардлагатай.
Татвар төлмөөргүй байна.
Улс нь ажилаа хийе
тур операторууд хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах
Төрөөс сайн дэмжмээр бн
Хамтран ажиллагч ханган нийлүүлэгчийн хүмүүсийг сургах, нэгдсэн стандарт хэм хэмжээг мөрдөх, дэд бүтцийг сайжруулах Бүх баазууд ЖХТ болон жолооч нарыг хүйсээр нь тусад нь оруулж байх.
Хөтөч нараас мөнгө авч энэ салбарыг хөгжүүлнэ гэдэг утгагүй... Төр өөрсдөө зохицуулах хэрэгтэй
ЖХТ нарын эрх ашгийн төлөөх ажлуудыг төрийн албаны үүрэг хариуцлаг шаардлагатай
Noiliin asuudal ih hund bdag bas uilchilgernii baiguulgiin hariltsaa hetduu bdag
Нийтийн бие засах газрыг олшруулах, цэвэр байлгах, зам дагуу газрыг цэвэрлэх.
Хөтөч тайлбарлагчийн нэгдсэн сан байгуулах
Бүх АЖ салбарын хэмжээнд
Хот бөглөрөлтэй хөдөө зам нь эвдрэл ихтэй 00 Амрах газар хүртээмжгүй, бохир гэх мэт наад захын шаардлага хангахгүй байдаг Гэтэл аялалын төлбөр нь өндөр байдаг болохоор их санаа зовдог
Хөтөч тайлбарлагчийг гэнэтийн ослын даатгалд хамруулаа
Төр аялал жуулчлалаа хөгжүүлэх хэрэгтэй
Нийтийн боловсон бие засах газар гол гол маршрутууд дээр байгуулах нэн шаардлагатай байгаа



Төр болон Монгол улсын бүх л хөтөч тайлбарлагчдын олонхын саналаар сонгогдсон төлөөлөх байгууллага

Үйлчилгээ сервис сайжруулах

Асар их юм байна зөв шидвэр гаргах

Guide-ийг мэргэжил зүгээс хүлээн авалгүй(ази зах зээл) дорд үзсэн байдлаар шаардлага биелүүлэхгүй байх хандлага(үйлчилгээний байгууллага, жолооч бусад нийгмийн харилцаанд үүсдэг) ажил мэргэжилийн талаар бүрэн ойлголтгүй явах мэргэжил нэг guide уудын гаргах ёсгүй ёс бус алдаанаас(еurope зах зээл, зарим тохиолдолд asian) жуулчид биднийг харах өнцөг муу талруу хувирах, бусдын алдаанаас нэг маршруттай явах тохиолдолд тухгүй байдал үүсэх(аялалыг нь талаас нь биднийг үргэлжлүүдэж өгч болох талаар тодруулах жуулчид байдаг ба үүнээс үүдэж хариуцсан хөтөч болон тур оператор гомдол гаргах) хэт их чимээ гаргах хөиөч ёс бцс хувцаслан жуулчдыг тухгүй байдалд оруулах, тайлбар ойр явахдаа буруу өгснөөр өөрийн аялалын тайлбар ахин өгч илүү их залрууллага хийх шаардлага үүсгэх, хамгаалалтын бүсэд шаардлага иавин эхэлсэн аялалд(чимээ гаргаж болохгүй, зориулалтын хувцас өмсөх, гэх мэт шаардлага тавин бэлдүүлж эхэлсэн аялалд ойр орчимд бусад хөтөч чанга дуу чимээ гаргах, хог хаях зэрэг) бидний тавидаг шаардлагыг мэргэжлийн хөтөч өөрөө зөрчиж харагддаг ба өвлийн аялалын үеэр зориулалтын бус бэлтгэлгүй явснаар бид аюултай замтай үед бусдын жуулчид болон хөтөчийг төлвөлсөн маршрутаас хазайж хүргэж өгөх гэх мэт асуудал үүсдэг) иймд бүх хөтөч талбарлагчдад тайлбар бүрэн өгөх чадвартай эсэх, ажлаа хийх явцад баримтлах журам, газрын зурагтай ажиллаж сурах гэх мэт аялалт явахаас өмнө хувийн бэлтгэл бүрэн хангсан эсэхийг шалгах нь зөв гэж үзэн мэргэжлийн үнэмлэхтэй болгох саналыг дэмжиж байна.

Хөтөч тайлбарлагчид улиралын чанартай ажилладаг ба маш бага аялал авах тохиолдолд үүсдэг ба улиралд 600.000 ийн хурамжийг эсэргүүцэж байна.

1. Хил, гаалийн ажилтнуудын харилцаа хандлагыг дээшлүүлэх
2. Тур операторуудын удирдлагуудыг эерэгшүүлэх Empathy буюу EQ сайжруулах
3. Жолооч нарт ёс зүйн гүн гүнзгий сургалт хийж, хэвшүүлэх, дадлагажуулах
4. Орон нутгийн чанартай хөтөч нарыг бэлдэж эхлэх

Ajil mergejildee bol durtai, ulam mergejilhiig husdeg. Harin ymar ch erh zuin eelteo orchin demjleg bhgui (niigmiin daatgal, tetgemj, zeel, blvisand oroh gh met) uchraas hetsuu bn. Tatvar huraamj ugmurgui bn

Ажил олгогч компаниудын мэргэжлийн үйл ажиллагааг сайжруулах.

600к хураамж арай их байна. Зуны хэдэн сар ажиллаж байж ийм төлбөр татаас төлнөө гэхээр

Нойл байдлаа сайжруул



yun 600k ve estoi demjihgui bn!!!!
МТО татвар өгөхгүй бх
Наад захын Мэлхий хадруу ордог замыг янзлах, үйлчилгээний газруудын /амралт ,хоолны газар гэх мэт./ харилцаа үйлчилгээн дээр анхаарах, үнийг хэт хөөргөлтийг хянах,
Ээлжит бус хурлыг яаралтай зарлах
Ажлын байрны тогтвортой байдал, бүтэн цагийн бусад ажилтай адилхан нийгмийн халамж авах боломжоор хангагдах. Зэрэглэл тогтооход цалинд нөлөөлөх боломжийг хангах, ЖХТ-ын эрхийг ажил олгогчдоос хамгаалах
Жуулчны хөтчийн стандартыг хатуу тавьж мөн хамтарч ажиллаж буй байгууллагууд илүү хариуцлагатай болох
Баазууд болон нислэгийн үнээ жигд байлгамаар байна. Жил болгон өөрчлөгдөж энэнд европ жуулчид бухимдангуй байдаг.
Төр нь хувийн хэвшлээс ангид, үйл ажиллагаанд оролцохгүй байх, хэрэгтэй хэрэггүй холбоод, мэргэжлийн байгууллагуудыг цөөлөх, татварын нөхцлийг уян хатан байлгах, татвар төлөөгүй, төлөхийг хүсээгүй хөтчийн ажил гүйцэтгэлд тухайн татвар авч буй байгууллага ямар нэгэн хэмжээгээр нөлөөлөхгүй байх, татварын асуудлыг ардчилсан, % хүн тухайн хөтөч сонголтоороо төлдөг болгох
Бүх сегментэд хяналт тавих санал асуулга үнэлгээ авах нээлттэй форм бий болгох
<ol style="list-style-type: none">1. Аялал жуулчлалын яам ядаж тэрэлжийнхээ хэдэн даваа болон мэлхий хад арьяабал хийд орох замыг сардаа нэг хусаж баймаар байна.2. Жуулчлалын улиралд үзвэрийн газруудад цагдаа байршуулж хамгаалалтаа нэммээр байна.3. Аялал автобусыг 1 эгнээгээр зорчихыг зөвшөөрмөөр байна. Жуулчид гацах гэж мөнгө төлөөгүй4. Хаа газар үзвэрийн газруудын зогсоолыг шийдэж өгмөөр байна.
Жуулчны хүлээлт хэт өндөр, монголд аялах дэд бүтэц, биологийн анхан шатны хэрэгцээг хангах байгууламж дутмаг байдгаас болж хөтөч заримдаа яаж ч хичээгээд дийлдэггүй, жуулчны сэтгэл ханамж буурдаг.
Стандарт маш сайн тогтоох
Aylal juuchlaliin yam ajlaa uhamsarlaj uurgее guitsetgeh shaardlagatai

<p>Нэгдсэн нэг мэдээллийн сантай байгаасай. Бидний мэдлэг мэдээлэл зөрдөггүй байгаасай гэж хүсдэг. Хэдий өөр өөр хэлээр хөтөч тайлбарлагч хийгээд явж байгаа ч гэсэн нэг л ажил мэргэшил хийгээд явж байгаагаас хойш хоорондоо мэнд устай эвтэй байвал сайхан юмсан. Тэгэхгүй хэл хэлээрээ зааглаад ялгаварлал гаргаж байгаад харамсдаг.</p>
<p>Хууль эрхзүйн орчинг ойлгогжтой нэгдсэн болгох</p>
<p>Төрийн байгууллагууд</p>
<p>00 ийн асуудлыг нэн даруй шийдэж өгөөсэй гэж хүсдэг.</p>
<p>баазын стадарт муу</p>
<p>Стандартад нийцсэн засах болон ариун цэврийн өрөөг шийдвэрдэж өгөх ялангуяа орон нутагт</p>
<p>Орон нутагт бие засах болон ариун цэврийн өрөөний асуудлыг нэн даруй шийдэж өгөх</p>
<p>Баазад эрчүүдтэй хоноход айдас түгшүүртэй байдаг.</p>
<p>Энэ салбарт өмнөх жилүүдийг бодвол төрийн оролцоо хэт их болж буйд санаа зовж бна.</p>
<p>Цалин урамшуулал нэмэгдүүлэх, мэргэжлийн нэгдсэн мэдээллийн сантай болох</p>
<p>Тур оператор, хөтөч, жуулчны баазууд харилцан уялдаж хаа хаанаа хариуцлагатай нэг нь нөгөөгөө дэмжсэн бусдынхаа ажлыг хүндэтгэсэн , бусдын эрх ашгийг хөндөхгүй зэрэг бүхий л тал дээр хамтран ажиллахад дор бүрнээ хичээх нь зөв гэж үздэг. % хүн, байгууллага бүр урд урдын алдаа оноогоо дүгнэж цаашид хаана, юуг, хэрхэн сайжруулах вэ? юун дээр зөвдөж юун дээр буруудаж байна гэх мэтээр үргэлж сайнд, сайжруулалтад тэмүүлдэг байгаасай.</p>
<p>Баазууд болон нислэгийн үнээ жигд байлгамаар байна. Жил болгон өөрчлөгдөж энэнд европ жуулчид бухимдангуй байдаг.</p>
<p>Хууль зүйн туслалцаа авахын тулд хандах байгууллага, утасны дугаар, холбогдох хаягийн мэдээллийг аялал жуулчлалын нийтлэг газруудад байршуулах, бодит туслалцаа үзүүлэх</p>
<p>Монголд өвлийн аялал жуулчлал хөгжөөсэй. Хэлтэй л бол ТО-ууд аялалаа хамаагүй мэргэжилийн бус хүнд өгөхгүй байгаасай. ЖХТ нь мөнгөнд улайрахгүй, жуулчныг дахин ирэх сэдэл төртөл нь сэтгэлд хүртэл нь үйлчилгээ үзүүлдэг байвал.</p>
<p>Даатгалууд, аялал жуулчлалын салбарт ажилладаг бүх хүн ямар нэг сургалтад хамрагдаж, боловсрох, үйлчилгээний салбарт ажиллаж байгаа ажилтнууд хүнд үйлчилж байна гэдгээ</p>



бүрэн ойлгосон байх (төлбөр нь төлөгдсөн, төлөх нь тодорхой эсвэл гэрээтэй газруудад очоод би өөрөө % даа юм гуйж байгаа юм шиг зогсоод байх их хэцүү)

чадварлаг боловсон хүчинг бэлдэх хэрэгтэй

Монголын АЖ Салбарт ердөө 4-5 том асуудал байдаг. Үүнд:

1. АЦ Байгууламж байхгүй буюу хүртээмж маш муу. АЦБ байлаа гэхэд бохир заваан, ялгадас ба шүвтэрийн үнэр нэвт ханхалж байдаг. Ихэнх жуулчны баазууд болон зам дагуух зоогийн газрууд адилхан.

2. Замын нөхцөл маш муу. Зам нь зэрэгцээ сөрөг урсгалтай тул эсрэг урсгалаас ослын аюул байнга заналхийлдэг.

3. Аяллын бүтээгдэхүүний хоорондох зай хол. Нэгээс гарч нөгөөд хүрэхийн тулд, дор хаяж хэдэн цагаар донсолгоотой замаар сэгсчүүлэх ёстой.

4. Нойр муутай хоносон (урд орой нь уусан, найрласан, архидсан, шоудсан эсвэл "буу халж" хоносон) улаан нүдтэй, ядарсан, санааширсан жолооч нар холын аян замд гардаг.

5. Хөтөч нарын мэдлэг, ур чадвар хангалтгүй бна. Ихэнх хөтөч нар түүх, соёл, уламжлал, зан заншил, нүүдэлчин ахуйн бодит мэдлэгээр хомс бна. Жишээ нь:

- Сүү өргөх бол эртний Монгол ёс гэж хэлэхээс цаашгүй. Яагаад, ямар утга учиртай талаар нарийн сайн мэдэхгүй.

- Тэнгэр шүтлэгийн ёс /Бөө онгод/ болон Буддын шашинь гүн ухааны талаар бол ойр зуур ерөнхий таамаг төдий ярихаас хэтрэхгүй байна.

- Эх түүхээ сайн мэдэхгүй төдийгүй, тухайн үзвэр бүтээгдэхүүнийг амилуулж нүдэнд харагдтал ярьж чадахгүй бна. Хадны сүг зураг, хүн/буган чулуун дээр жуулчид авч очлоо гэхэд "за нөгөөх чинь энэ байна" гээд зогсож байх жишээний...

- What makes it special? гэх асуултанд хариулах хандлагаар өөрийгөө бэлдсэн хөтөч өдрийн од мэт цөөн.

- Монголын эзэнт гүрнийг байгуулахад нийт хэдэн жил зарцуулсан бэ? эсвэл Их Монгол улс нийт хэдэн жил оршин тогтнов? гэхэд шууд хариулах хөтөч цөөхөн дөө, цөөхөн...

Сэтгэл хангалуун байдаг аа.

Huuli

Oilgomjtoi yum asuuh yum erguu sda we ene salbaraa aytaihan bolgo bitgii bidnariigaa shulah huuli batlaad bai

Өөрөө мэргэжлээ дээшлүүлэх бүх л боломжийн сургалтанд хамрагдаад, өөрөө даатгалаа төлөөд, ажил дээрээ асуудал гаргаж үзээгүй учир хэцүү зүйл байдаггүйээ.

Жуучны баазууд зарим нь жолооч, хөтөчийг огт хүн гэж үздэггүй, олон хоног ядраад явж байхад хамгийн муу байр өгдөг, энэ нь огт таалагддаггүй.



<p>Ур чадвар харилцааны сургалтыг зөвхөн хөтөч нарт бус жолооч, үйлчилгээний ажилтнуудад давхар олгох хэрэгтэй санагддаг</p>
<p>Жхт нийгмийн асуудалд дэмжих</p>
<p>Хөтчийг хамгаалах, ХАБЭА г мөрдүүлэх</p>
<p>Хөдөө орон нутгийн зам янзлах, баазуудын орчинг сайжруулах, 600,000 үндэслэлгүй татвар төлүүлэхгүй байх. Татвар авах гэж байгаа бол ямар үндэслэл, төсөв дээр тулгуурлан энэ үнийн дүнг гаргасанаа ил тодорхой тайлбар өгөх хэрэгтэй. Бүх гишүүдийн хурлаар гэж хэдэн хүний оролцоотой хурлаар яагаад 600,000 гэсэн тоо гаргасанаа сайн тайлбарлаж өгөх хэрэгтэй байх. Зөвхөн хууль дүрэм, журам ярих нь утгагүй байна</p>
<p>Мэргэжил нэгт нөхөд маань энэ ажлыг хайнгадуу, үл ойшоосон, түр зуурын гэмээр хандлагатай хийж байгаад нь сэтгэл зовнидог.</p>
<p>Жуулчдад үзүүлэх наад захын үйлчилгээ болох замын 00, гуанзны нөхцөлийг сайжруулах нэн шаардлагатай байна</p>
<p>Үндэсний хэв маягийг хадгалсан хантааз юм уу тийм хувцсаар жигдрэх</p>
<p>Bugd 1</p>
<p>Жуулчны баазуудын хөтөчтэй хандаж буй хандлага маш муу, хөтөчийн байр маш хөгийн байдаг. Байнга хэцүү зам туулаад хэдэн хоногоор ажиллаж буй хөтчүүдэд тухтай амрах байраар хангах тал дээр баазууд анхаарах. 600,000₮ хураамж төлж чадахгүй. хүн бүрийн орлого харилцан адилгүй. НДШ-ээс гадна давхар хураамж авахаа болино уу!!!</p>
<p>Наад захын хэрэгцээ болох нийтийн боловсон жорлонг нэмэх, баазуудын тоог нэмэх,</p>
<p>2003 оноос энэ салбарт ажиллаж байна. Олон ч удаа шантарч байсан. Тийм ч бас амар ажил биш. Үндсэн ажилчны тоонд орохгүй шах уу ажиллана. Учир нь зуны цөөхөн сар ажилладаг. Ямар нэгэн гэнэтийн осолд өртөхөд ямар ч баталгаа, даатгал бидэнд байхгүй. Бор зүрхээрээ өөдрөг сэтгэлээр хандаад тийм зүйл болохгүй мэт л явдаг гэтэл бид маш том эрсдэл дунд ажилладаг. Заримдаа явуулж байгаа машин тэрэг, морь, бааз, байрлах газар нь тухайн аяллын чанарын шаардлага хангахааргүй ч байдаг. Сүүлийн хэдэн жил хамтран үйлчилж байгаа байгууллагуудын үйлчилгээ, хоол гэх зүйлс маш их дордсон. Сүүлийн хэдэн жил ажиллахад хүнд болсон. Маш их стресстэй; замын түгжрэл, групп жуулчдад наадмын нээлт үзэхэд нэг доор суудал хүрэлцэхгүй, аюулгүй орчин байхгүй, гаргасан шийдвэр нь байнга өөрчлөгдөх гээд үнэхээр стресстэй. Бичвэл их зүйл байна даа. Ууг нь утаагүй үйлдвэр гэдгээрэй мөн нутгийн жирийн иргэдэд ч орлого олох сайхан салбар. Үнэхээр сайхан гэгээлэг гоё болохоор өнөөг хүртэл орхиж чадахгүй ажиллаж бага ч боловч өөрийнхөө % нэмрээ оруулж явна.</p>



Үйлчилгээний байгууллагууд компаний засаглалаа сайжруулж илүү үр бүтээлтэй цагийн зохицуулалт сайтай байвал.

Гайдтай хийх гэрээний заалтыг хэрэгжүүлэх

Хууль эрх зүйн орчинг сайжруулах, хянах, шаардлага тавих

Цалин урамшуулал нэмэгдүүлэх, мэргэжлийн нэгдсэн мэдээллийн сантай болох

АЖМХолбоо нэгэнт төр, хувийн хэвшлийг холбож ажиллах статустай тул мэргэжлийн сургалтуудыг МХТХолбоотой хамтарч зохион байгуулах, гадаад оронд хүний нөөцийг бэлдэх, чадавхижуулах, чанаржуулах сургалт, сургалтын аяллуудыг олноор үр дүнтэй гүйцэтгээсэй